



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/157

Булган

**Ажлын хэсэг шинэчлэн томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Газрын тухай хуулийн 52 дугаар заалт, Улсын Их Хурлын 2015 оны 104 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 2.1.10, 2.1.11, 2.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Швейцарийн хөгжлийн агентлагаас бэлчээрийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх чиглэлээр 2017-2020 онуудад Сайхан, Могод, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Орхон сумдад хэрэгжүүлэх “Ногоон-алт, малын эрүүл мэнд” төслийн ажлыг зохион байгуулах, аймаг, төсөл хоорондын ажлыг зохицуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: - О.Гантулга /Аймгийн Засаг даргын орлогч/

Гишүүд: - Д.Буманбаяр /аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга/

- Ч.Амгалан /ХХААГ-ын дарга/

- Ү.Бямбасүрэн /ГХБХБГ-ын дарга/

- С.Жаргалсайхан /УЦУОШТ-ийн дарга/

- Ц.Энхмаа /аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн/

- Б.Отгонжаргал /ГХБХБГ-ын мэргэжилтэн/


- Т.Жаргалант /Булган аймгийн Бэлчээр ашиглагчдын холбооны гүйцэтгэх захирал/

Нарийн бичгийн дарга: - М.Жавзандолгор /ХХААГ-ын МАА-н албаны дарга/

2. Бэлчээр ашиглалтын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын уялдаа холбоог хангаж ажиллахыг ажлын хэсэг /О.Гантулга/-т даалгасугай.

3. Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/451 тоот Ажлын хэсэг томилох тухай захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190187